



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 43

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 158,052,180 /нэг зуун тавин найман сая тавин хоёр мянга нэг зуун наяд төгрөгийн анхны өртөгтэй, 5,291,448 /таван сая хоёр зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун дөчин нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй сургуулийн барилгыг актлан данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, ашиглаж болох эд зүйлд хавсралтын дагуу үнэлгээ тогтоон худалдаж, худалдсанаас орох орлогоор уг хөрөнгийг буулгах зардалд зарцуулахыг Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Цэрэн-Янжинд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.


ДАРГА

С.БУДЖАВ



#100087

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 04 сарын  
01 өдрийн 13-р тогтоолын хавсралт



Хичээлийн 2-р байрны барилгын материалын худалдах үнийн санал

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Худалдах үнийн санал
1	Түүхий зузаан цагаан тоосго	ш	3000	50	150,000
2	Вакум цонх	ш	25	30000	750,000
3	Нимгэн банз /1-3 см өргөн, 3 м урт/	ш	380	1500	570,000
4	Зузаан банз /5 см-с дээш өргөн, 3 м урт	ш	300	2400	720,000
5	Палк /2 м урт/	ш	66	2400	158,400
6	Шалны банз /3 м урт/	ш	300	1800	540,000
7	Хаалга /хятад/	ш	12	2000	24,000
8	Секц /паар, хятад/	ш	162	1500	243,000
9	Бүдүүн труба /32, 40 хятад/	м	30	1000	30,000
10	Нарийн труба /хятад/	м	20	800	16,000
11	Ислэг хавтан /1.8*2.8 орос/	ш	25	800	20,000
12	Дээврийн төмөр /0.9*7м/	ш	34	3000	102,000
Нийт дүн					3,323,400